



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн “Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БНА-2026/005/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Баянхонгор хот

2026

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх  
аудитор: Б.Мөнхбат  
Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn  
Аудитын менежер М.Алтантуяа  
Утас: 99061829 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn  
Аудитор Д.Оюун-Эрдэнэ  
Утас: 88916603 Цахим хаяг: oyun-erdenede@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	6
3. ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ .....	10
4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	11
5. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	12

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101

Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2026.03.16 № 2/145

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

Г **Хязгаарлалттай дүгнэлт** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянхонгор аймгийн “Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон эдийн засгийн үзүүлэлтүүд, зорилтот түвшний гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

#### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Батлагдсан төсвийг тээвэр шатахууны зардал 24,029.0 мянган төгрөгөөр, урсгал засварын зардал 36,431.2 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.

Өмнөх оны 33,903.5 төгрөгийн шатахууны өр, 26,184.9 мянган төгрөгийн ХХОАТ-ын өрийг төлж барагдуулаагүй байна.

Арилжааны банкны дансаар орсон хог хаягдлын хураамжийн орлого 6,465.0 мянган төгрөг, тендерийн орлого 105.0 мянган төгрөг, нийт 6,465.0 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэлгүйгээр үйл ажиллагаандаа зарцуулсан зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

6426050412  
/2026 он/1. бичиг хэрэг/тоот/2. а4-  
албан тоот.docx

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-т “Хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.2.2-т “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх”, 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-т “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтуудыг зөрчиж байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Тайлант онд халуун устай оффисын барилга хүлээн авч 12 дугаар сард ашиглалтад оруулсан.

Мөн Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 10/77 дугаар тогтоолоор аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 258,000.0 мянган төгрөгийн өөрөө буулгагч-25 тонны даацтай, өөрөө шахагч-12 тонны даацтай 2 автомашин, Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 9/61 дугаар тогтоолоор 16,966.3 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй Toyota land cruiser автомашиныг балансаас баланс хооронд шилжүүлэн авсан, Баянхонгор аймгийн ИТХ-ын 2025 оны 5/05 дугаар тогтоолоор шинэ хөдөө төслийн хүрээнд хийлүүлэгдсэн 25,000.0 мянган төгрөгийн хуванцар сав преслэгч машин, Баянхонгор аймгийн Засаг даргын 2025 оны “Онцгой комиссын дотоодын хүмүүнлэгийн бараа материал хуваарилан олгох тухай” А/223 дугаар захирамжаар 44,590.5 мянган төгрөгийн бараа материал зэрэг хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэж, тайлагнасан байна.

Тайлант онд 244,236.2 мянган төгрөгийн төгрөгийн ашигтай ажилласан нь 344,556.8 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материал хүлээн авснаас шалтгаалжээ.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилт, 39 арга

хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 91.8 хувиар үнэлсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТӨРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>52,189,493.98</u></b>	<b><u>104,370,667.68</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>923,142.82</b>	<b>999,621.52</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>923,142.82</b>	<b>999,621.52</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>923,142.82</b>	<b>999,621.52</b>
31213	Арилжааны банк дахь харилцах	923,142.82	999,621.52
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>2,534,590.16</b>	<b>2,534,590.16</b>
33401	Дансны авлага /ТӨҮГ/	1,080,000.00	1,080,000.00
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	1,454,590.16	1,454,590.16
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>48,731,761.00</b>	<b>100,836,456.00</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>47,351,761.00</b>	<b>99,456,456.00</b>
35410	Бичиг хэргийн материал	1,096,290.00	1,127,810.00
35420	Аж ахуйн материал	44,294,771.00	93,077,996.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,960,700.00	5,250,650.00
35600	Мал амьтад	1,380,000.00	1,380,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>535,989,871.09</u></b>	<b><u>714,242,949.75</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>535,989,871.09</b>	<b>714,242,949.75</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>497,769,871.09</b>	<b>676,022,949.75</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	17,220,049.00	17,220,049.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(12,054,034.30)	(13,776,039.20)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	797,770,333.00	1,185,338,772.64
39204	Хуримтлагдсан элэгдэл	(452,867,142.78)	(637,733,796.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	20,425,000.00	47,960,105.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(7,452,777.78)	(14,653,382.09)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,590,900.00	6,370,900.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(4,487,566.66)	(4,870,400.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	219,116,851.00	219,116,851.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(86,491,740.40)	(128,950,110.60)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>38,220,000.00</b>	<b>38,220,000.00</b>
39301	Програм хангамж	869,000.00	869,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(869,000.00)	(869,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	38,220,000.00	38,220,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>588,179,365.07</u></b>	<b><u>818,613,617.43</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>79,527,933.55</u></b>	<b><u>65,726,025.50</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>79,527,933.55</b>	<b>65,726,025.50</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>79,527,933.55</b>	<b>65,726,025.50</b>
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>79,527,933.55</b>	<b>65,726,025.50</b>
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	26,184,864.27	30,671,402.76
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	19,161,536.15	-
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	34,181,533.13	35,054,622.74
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>508,651,431.52</u></b>	<b><u>752,887,591.93</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>508,651,431.52</b>	<b>752,887,591.93</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	612,440,438.00	612,440,438.00
51101	Өмч: - төрийн	612,440,438.00	612,440,438.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(103,789,006.48)</b>	<b>140,447,153.93</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(145,964,866.19)	(103,789,006.48)
51220	Тайлант үеийн үр дүн	42,175,859.71	244,236,160.41
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>588,179,365.07</u></b>	<b><u>818,613,617.43</u></b>

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,567,887,430.00</b>	<b>2,279,896,141.13</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,567,887,430.00</b>	<b>2,279,896,141.13</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,567,887,430.00</b>	<b>2,279,896,141.13</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	381,896,141.13
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого		37,339,298.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Үндсэн хөрөнгө/		299,966,343.13
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Бараа материал/		44,590,500.00
120009	Бусад орлого	122,130,000.00	
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	1,445,757,430.00	1,898,000,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,525,711,570.30</b>	<b>2,035,659,980.72</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,525,711,570.30</b>	<b>2,035,659,980.72</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,525,711,570.30</b>	<b>2,035,659,980.72</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,525,711,570.30</b>	<b>2,035,659,980.72</b>
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/	381,054,282.63	27,315,000.00
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	631,704,501.52	1,200,144,399.57
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/	366,972,276.15	533,093,721.67
210813	Бусад зардал /ТӨҮГ/	145,980,510.00	275,106,859.48
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>42,175,859.71</b>	<b>244,236,160.41</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>42,175,859.71</b>	<b>244,236,160.41</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,446,652,030.00</b>	<b>1,935,339,298.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,446,652,030.00</b>	<b>1,935,339,298.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,446,652,030.00</b>	<b>1,904,795,298.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	6,795,298.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос		6,795,298.00
120009	Бусад орлого	13,752,030.00	
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	1,432,900,000.00	1,898,000,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>-</b>	<b>30,544,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>-</b>	<b>30,544,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		10,944,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		19,600,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,445,759,087.57</b>	<b>1,932,727,714.30</b>

Баянхонгор аймгийн “Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,445,759,087.57</b>	<b>1,932,727,714.30</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,445,759,087.57</b>	<b>1,932,727,714.30</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>631,704,501.52</b>	<b>855,493,779.19</b>
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	631,704,501.52	855,493,779.19
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>212,537,907.10</b>	<b>269,016,865.15</b>
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	212,537,907.10	269,016,865.15
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>9,706,200.00</b>	<b>18,842,717.00</b>
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	9,706,200.00	18,842,717.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>394,126,476.15</b>	<b>504,639,961.08</b>
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	366,972,276.15	422,924,511.08
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	27,154,200.00	81,715,450.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>197,684,002.80</b>	<b>284,734,391.88</b>
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	51,703,492.80	78,335,840.89
210817	Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/	-	871,821.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	145,980,510.00	205,526,729.99
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>892,942.43</u></b>	<b><u>2,611,583.70</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	-	<b>2,535,105.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>2,535,105.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	2,535,105.00
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	-	2,535,105.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	-	<b><u>(2,535,105.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>892,942.43</b>	<b>76,478.70</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>30,200.39</b>	<b>923,142.82</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>923,142.82</b>	<b>999,621.52</b>

**2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	612,440,438.00	-	(145,964,866.19)	-	466,475,571.81
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	612,440,438.00	-	(145,964,866.19)	-	466,475,571.81
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	42,175,859.71	-	42,175,859.71

Баянхонгор аймгийн “Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	612,440,438.00	-	(103,789,006.48)	-	508,651,431.52
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	612,440,438.00	-	(103,789,006.48)	-	508,651,431.52
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	612,440,438.00	-	(103,789,006.48)	-	508,651,431.52
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	244,236,160.41	-	244,236,160.41
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	612,440,438.00	-	140,447,153.93	-	752,887,591.93

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

Д/Д	Зардал	2025 он		Хэтрэлт, хэмнэлт	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,898,000,000.00</b>	<b>1,935,339,298.00</b>	(37,339,298.00)	102.0
2	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,350,000,000.00</b>	<b>1,369,600,000.00</b>	(19,600,000.00)	101.5
3	Орон нутгийн төсвөөс	1,350,000,000.00	1,350,000,000.00	-	100.0
4	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		19,600,000.00	(19,600,000.00)	
5	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>548,000,000.00</b>	<b>565,739,298.00</b>	(17,739,298.00)	103.2
6	Санхүүгийн дэмжлэг /сумын орон нутгийн орлогоос/	470,000,000.00	470,000,000.00	-	100.0
7	Өмнөх оны хог хаягдлын хураамжийн давсан орлого	78,000,000.00	78,000,000.00	-	100.0
8	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	10,944,000.00	(10,944,000.00)	
9	Үндсэн үйл ажиллагааны орлого	-	6,465,000.00	(6,465,000.00)	
10	Харилцах үлдэгдэл	-	330,298.00	(330,298.00)	
11	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,898,000,000.00</b>	<b>1,935,262,819.30</b>	<b>(37,262,819.30)</b>	<b>102.0</b>
12	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,898,000,000.00</b>	<b>1,935,262,819.30</b>	<b>(37,262,819.30)</b>	<b>102.0</b>
13	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,880,020,000.00</b>	<b>1,914,771,319.30</b>	<b>(34,751,319.30)</b>	<b>101.8</b>
14	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,203,177,000.00</b>	<b>1,206,283,856.00</b>	<b>(3,106,856.00)</b>	<b>100.3</b>
15	Үндсэн цалин	1,203,177,000.00	1,206,283,856.00	(3,106,856.00)	100.3
17	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>156,303,400.00</b>	<b>156,499,341.00</b>	<b>(195,941.00)</b>	<b>100.1</b>
18	Тэтгэврийн даатгал	156,303,400.00	156,499,341.00	(195,941.00)	100.1
19	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>36,276,600.00</b>	<b>36,027,813.00</b>	<b>248,787.00</b>	<b>99.3</b>
20	Гэрэл, цахилгаан	3,138,700.00	2,889,913.00	248,787.00	92.1

Баянхонгор аймгийн “Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

21	Түлш, халаалт	19,277,900.00	19,277,900.00	-	100.0
22	Цэвэр, бохир ус	660,000.00	660,000.00	-	100.0
23	Байрны түрээс	13,200,000.00	13,200,000.00	-	100.0
24	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>284,961,400.00</b>	<b>304,964,170.00</b>	(20,002,770.00)	107.0
25	Бичиг хэрэг	3,812,400.00	2,454,900.00	1,357,500.00	64.4
26	Тээвэр, шатахуун	272,686,500.00	296,715,466.00	(24,028,966.00)	108.8
27	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,408,000.00	764,404.00	2,643,596.00	22.4
28	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,054,500.00	5,029,400.00	25,100.00	99.5
29	<b>Нормативт зардал</b>	<b>15,680,000.00</b>	<b>9,805,330.30</b>	5,874,669.70	62.5
30	Нормын хувцас, зөөлөн эдлэл	15,680,000.00	9,805,330.30	5,874,669.70	62.5
31	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>171,327,100.00</b>	<b>189,248,500.00</b>	(17,921,400.00)	110.5
32	Багаж, техник, хэрэгсэл	61,464,000.00	47,828,255.00	13,635,745.00	77.8
33	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	34,863,100.00	29,989,050.00	4,874,050.00	86.0
34	Урсгал засвар	75,000,000.00	111,431,195.00	(36,431,195.00)	148.6
37	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>12,145,400.00</b>	<b>11,793,209.00</b>	352,191.00	97.1
39	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
40	Даатгалын үйлчилгээ	1,829,400.00	1,829,400.00	-	100.0
41	Тээврийн хэрэгслийн татвар	950,000.00	950,000.00	-	100.0
42	Тээврийн хэрэгслийн оношлогоо	616,000.00	616,000.00	-	100.0
43	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	7,750,000.00	7,397,809.00	352,191.00	95.5
44	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>149,100.00</b>	<b>149,100.00</b>	-	100.0
45	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	-	-
46	Газрын төлбөр	149,100.00	149,100.00	-	100.0
47	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>17,980,000.00</b>	<b>20,491,500.00</b>	(2,511,500.00)	114.0
48	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>17,980,000.00</b>	<b>20,491,500.00</b>	(2,511,500.00)	114.0
49	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	17,980,000.00	20,491,500.00	(2,511,500.00)	114.0
50	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>923,142.82</b>		
51	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>999,621.52</b>		

### 3. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Ажилчдын дансруу мөнгө шилжүүлэн худалдан авалт хийж буй төлбөр тооцооны анхан шатны баримтын бүрдэл, нохой муурны устгалд зориулж худалдан авч буй сумны худалдан авалтыг орон нутгийн өмчит газруудын гүйцэтгэлийн аудитаар шалгах.

## 4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 344,556.8 мянган төгрөгийн 1 алдаа<sup>1</sup> илэрсэнийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Тайлант онд үнэ төлбөргүй шилжиж ирсэн 299,966.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 44,590.5 мянган төгрөгийн бараа материал, нийт 344,556.8 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бус эздийн өмчийн бусад хэсгийг нэмэгдүүлэн бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 4 дүгээр зүйлийн 4.1.1, НББОУС-20 Засгийн газрын буцалтгүй тусламжийн нягтлан бодох бүртгэл 22-28 дахь заалт, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар нийт 69,925.2 мянган төгрөгийн зөрчил илэрч 3,000.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 66,925.2 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж хүргүүлэв.

### 4.1 Зөвлөмж

1. Тайлант онд арилжааны банкны дансаар хог хаягдлын хураамжийн орлого 6,465.0 мянган төгрөг, тендерийн орлого 105.0 мянган төгрөг, нийт 6,465.0 мянган төгрөгийн орлого орж ирснийг орон нутгийн орлогод төвлөрүүлэлгүйгээр үйл ажиллагаандаа зарцуулсан байна..

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын арилжааны банкинд төвлөрсөн үйлчилгээний орлого болон бусад орлогыг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлж, батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах.

2. Тээвэр шатахууны зардлыг 24,029.0 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 36,431.2 мянган төгрөгөөр батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан. Өмнөх оны 33,903.5 төгрөгийн шатахууны өр, 26,184.9 мянган төгрөгийн ХХОАТ-ын өрийг төлж барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг хэтрүүлэн бараа, үйлчилгээ худалдан авахгүй байх, өмнөх онд үүссэн өр төлбөрүүдийг бүрэн барагдуулах, өр төлбөр үүсгэхгүй үр ашигтай ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

### 4.2 Төлбөрийн акт

Ажилчдад 2025 оны 05 дугаар сард цалингийн урьдчилгаанд тус бүр 1,500.0 мянган төгрөг, нийт 3,000.0 мянган төгрөг олгосон ба суутган тооцоо хийгээгүй

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

байна. Тус ажилчид нь 2025 оны 7 болон 8 дугаар саруудад ажлаас чөлөөлөгдсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-т “Хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Баянхонгор аймгийн “Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын захирлын 2025 оны Б/85, Б/93 дугаар тушаалын 3-т “ажлаас гарч буй ажилтантай холбоотой цалин хөлс, эд хөрөнгийн тооцоо хийж дуусгахыг Ерөнхий нягтлан бодогчид, ажил хүлээлцсэн акт үйлдэн танилцуулахыг ажлын хэсэгт тус тус даалгасугай” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цалингийн урьдчилгаанд олгосон 3,000.0 мянган төгрөгийг нягтлан бодогчоор төлүүлж, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт Төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/			
							Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд үнэ төлбөргүй шилжиж ирсэн 299,966.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 44,590.5 мянган төгрөгийн бараа материал, нийт 344,556.8 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бус эздийн өмчийн бусад хэсгийг нэмэгдүүлэн бүртгэж тайлагнасан байна.	1	344,556.8			1	344,556.8	1	344,556.8		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>344,556.8</b>					<b>1</b>	<b>344,556.8</b>		

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ажилчдад 2025 оны 05 дугаар сард цалингийн урьдчилгаанд нийт 3,000.0 мянган төгрөг олгосон ба суутган тооцоо хийгээгүй байна.	1	3,000.0	1	3,000.0				
2	Тайлант онд арилжааны банкны дансаар хог хаягдлын хураамжийн орлого 6,465.0 мянган төгрөг, тендерийн орлого 105.0 мянган төгрөг, нийт 6,465.0 мянган төгрөгийн орлого орж ирснийг орон нутгийн орлогод төвлөрүүлэлгүйгээр үйл ажиллагаандаа зарцуулсан байна.	1	6,465.0					1	6,465.0
3	Тээвэр шатахууны зардлыг 24,029.0 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 36,431.2 мянган төгрөгөөр батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан. Өмнөх оны 33,903.5 төгрөгийн шатахууны өр, 26,184.9 мянган төгрөгийн ХХОАТ-ын өрийг төлж барагдуулаагүй байна.	1	60,460.2					1	60,460.2
	<b>Дүн</b>	<b>3</b>	<b>69,925.2</b>	<b>1</b>	<b>3,000.0</b>			<b>1</b>	<b>66,925.2</b>

-----oOo-----